



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 0/260

Мандалговь

Г Малын гоц халдварт өвчний талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 /а/, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 10 дугаар зүйлийн 10.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Өлзийт хороо, Төв аймгийн Сэргэлэн суманд малын гоц халдварт шүлхий өвчин, Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт хонины цэцэг өвчин гарсан тул дээрх голомттой газруудаас 2017 оны 07 сарын 28-30 өдрүүдэд Дундговь аймагт болох "Говийн бүсийн хурд" наадамд хурдан морьдыг оролцуулах, мал амьтныг тус аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхийг тус тус хориглосугай.

Хоёр. Малын гоц халдварт өвчний сэжиг бүхий нутгаас ирж байгаа иргэд, малын хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийх, пост байгуулан халдваргүйжүүлэлт хийх, хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сум /Р.Мөнхтогтох/, Дэлгэрцогт сум /Б.Иш-Ёндон/, Дэрэн сум /Н.Мядагмаа/, Адаацаг сум /Ж.Батхөлөг/-д нарт үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтийг хангаж мэргэжлийн удирдлага арга зүй, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Б.Фчирдорж/, Онцгой байдлын газар /Я.Алтанхундага/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Б.Мөнхжаргал/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ж.Мөнхчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200750